

## ХАР БҮС, ДАНЫ ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь Дэлхийн Таеквондогийн Хар бүс дан зэрэг эзэмших, Дан зэрэг ахиулах шалгалтын зохион байгуулалт, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Журмын биелэлтэд Монголын Таеквондогийн холбоо хяналт тавина.
- 1.3. Шалгалтыг Монголын Таеквондогийн холбоо зохион байгуулна.
- 1.4. Шалгалтанд бүртгүүлэгч нь Монголын Таеквондогийн холбооны сургалтын стандартад тусгагдсан мэдлэг, чадварыг эзэмшсэн байна.

### Хоёр. Шалгалтын бүртгэл

- 2.1 Бүртгүүлэгч нь шалгалтанд оролцох хүсэлтээ өөрийн харьяа клуб, спорт хороогоор дамжуулан Монголын таеквондогийн холбоонд хүсэлтээ илгээнэ
- 2.2 Бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна:
  - 2.2.1 Иргэний үнэмлэх буюу түүнтэй адилтгах бичиг баримт;
  - 2.2.2 Цээж зураг /сүүлийн 3 сарын дотор авахуулсан 3х4 см хэмжээтэй/;
  - 2.2.3 Өмнө нь дан авч байсан бол тухайн данийн үнэмлэхний хуулбар;
- 2.3 Шалгалтын бүртгэлийн хураамжийг төлснөөр бүртгэл баталгаажна.
- 2.4 Шалгалтын бүртгэлийн хугацаа шалгалт эхлэхээс 5 хоногийн өмнө хаагдана.
- 2.5 Хэрэв шалгалтын бүртгэлийг цуцлахаар бол Монголын таеквондогийн холбоонд хүсэлт гарган бүртгэлийн хугацаа дуусахаас өмнө бүртгэлийг цуцлуулж болно.

### Гурав. Шалгалтын хураамж

- 3.1 Шалгалтын хураамж нь тухайн дэвшиж буй дан тус бүрт доорх байдлаар байна.

Д/д	Зэрэг	Шалгалтын хураамж
1	1-р Дан/Пүм	100 Ам.доллар
2	2-р Дан/Пүм	120 Ам.доллар
3	3-р Дан/Пүм	150 Ам.доллар
4	4-р Дан/Пүм	180 Ам.доллар
5	5-р Дан	200 Ам.доллар
6	6-р Дан	230 Ам.доллар
7	7-р Дан	250 Ам.доллар
8	8-р Дан	270 Ам.доллар
9	Давтан шалгалт	10 Ам.доллар

3.2 Бүртгүүлэгч нь шалгалтын хураамжийг Монголын таеквондогийн холбооны дансанд тушаана.

3.3 Бүртгэлийг цуцалсан /журмын 2.5 дахь зүйлд заасны дагуу/ тохиолдолд шалгалтын хураамжийн 75% буцаан олгоно.

3.4 Бүртгүүлэгч нь шалгалтанд ороогүй тохиолдолд шалгалтын хураамжийг буцаан олгохгүй, бусдад болон дараагийн шалгалтанд шилжүүлэн тооцохгүй.

#### **Дөрөв. Шалгалтын дүн**

4.1 Шалгалтад 80% ба түүнээс дээш үнэлгээ авсан тохиолдолд тэнцэнэ.

4.2 Шалгалтанд тэнцээгүй тохиолдолд давтан шалгалт өгнө.

4.3 Шалгалтын комисс нь шалгалтад орсон тамирчны шалгалтын үр дүнгийн мэдээллийг тухайн тамирчны бүртгүүлсэн и-мэйл хаягаар болон утсаар ажлын долоо хоногийн дотор мэдэгдэнэ.

#### **Тав. Гэрчилгээ олгох**

5.1 Амжилттай шалгуулагчид Дэлхийн Таеквондогийн дээд байгууллага Куккивоны батламжилсан гэрчилгээ болон үнэмлэхийг олгоно.

5.2 Гэрчилгээг шалгалтын дүн зарлагдсанаас хойш 60 хоногийн дотор олгоно.

#### **Зургаа. Бусад**

6.1 Шалгалттай холбоотой санал, хүсэлт, гомдлыг Монголын таеквондогийн холбооны [mongoliatekwondo@gmail.com](mailto:mongoliatekwondo@gmail.com) цахим шуудангаар илгээж болно.